



## САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Галуут сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: БНА-2024/16/НА-СТА-ТТЗ

Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Баянхонгор хот 2024 оны 03 дугаар сарын 25-ны өдөр	Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын Дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат Утас: 70442584 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn  Ахлах аудитор М.Алтантуяа Утас: 70442424 Цахим хаяг: altantuyam@audit.gov.mn  Ахлах аудитор Б.Должмаа Утас: 88110538 Цахим хаяг: doljmaab@audit.gov.mn
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

**АГУУЛГА**

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ .....	2
<b>Аудитын гол асуудал</b> .....	2
1. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ .....	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан (мянган төгрөгөөр) .....	4
Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан (мянган төгрөгөөр) .....	4
2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан (мянган төгрөгөөр).....	5
2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан (мянган төгрөгөөр).....	7
Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан (мянган төгрөгөөр).....	7
Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан (мянган төгрөгөөр).....	9
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	9
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа .....	9
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт .....	9
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	10
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд.....	10
3.4.1 Мөнгөн хөрөнгө.....	10
3.4.2 Авлага .....	11
3.4.3 Бараа материал .....	11
3.4.4 Үндсэн хөрөнгө .....	12
3.4.5 Өр төлбөр .....	13
3.4.6 Засгийн газрын хувь оролцоо.....	13
3.4.7 Орлогын данс .....	13
3.4.8 Зардлын данс .....	15
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	15
4. АУДИТЫН ТАЙЛАН.....	17
4.1. Ерөнхий зүйл .....	17
4.2 Материаллаг байдал.....	17
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт.....	17
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	18
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	18
4.7 Аудитын гол асуудал.....	18
Аудитын илрүүлэлт.....	20
5.1. АЛБАН ШААРДЛАГА.....	20
Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл .....	20

**Товчилсон үгийн жагсаалт**

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн хурал
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
СТСХ	Санхүү, төрийн сангийн хэлтэс
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ЭМТ	Эрүүл мэндийн төв





ГАЛУУТ СУМЫН ЗАСАГ  
ДАРГА А.БАТБАЯР ТАНАА

**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

310 дугаар байр, Лувсанданзанжанцангийн  
өргөн чөлөө 3 дугаар гудамж, Номгон 1 дүгээр баг,  
Баянхонгор сум, Баянхонгор аймаг, 64101  
Утас: (976) 70442584

Цахим шуудан: procurement\_bayankhongor@audit.gov.mn

2024.03.25 № 2/108

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.3-д заасны дагуу Галуут сумын Засаг даргын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Галуут сумын Засаг даргын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

Галуут сумын Засаг даргын харьяаны 2 төсвийн байгууллага, 2 тусгай санд Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газар санхүүгийн тайлангийн аудит хийж түүвэрт хамрагдсан байна.

**Аудитын гол асуудал**

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

5020400

Галуут сумын Засаг даргын харьяаны байгууллагуудын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар 8,039.6 мянган төгрөгийн 5 алдаа, зөрчил илэрснээс байгууллагуудын санхүүгийн тайланд 895.9 мянган төгрөгийн 2 алдааг залруулж, 200.0 мянган төгрөгийн 1 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 6,943.7 мянган төгрөгийн 2 албан шаардлага хүргүүлжээ.

#### **Бусад асуудлын хэсэг**

Галуут сумын Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайлангаас бусад үйл ажиллагааны тайлан, мэдээ, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт зэрэг мэдээлэлтэй танилцахад материаллаг буруу илэрхийлсэн зүйл илрээгүй.

#### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

#### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР

Б.МӨНХБАТ

**1. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ**  
2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

**2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан (мянган төгрөгөөр)**

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>853,675.7</b>	<b>770,728.0</b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	<b>495,642.7</b>	<b>452,767.3</b>
<b>31200</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	<b>495,642.7</b>	<b>452,767.3</b>
<b>31210</b>	<b>Төгрөг</b>	<b>495,642.7</b>	<b>452,767.3</b>
31211	Төрийн сангийн харилцах	495,642.7	452,767.3
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	<b>231,767.0</b>	<b>250,190.2</b>
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	523.7	1,183.0
<b>33500</b>	<b>Бусад авлага</b>	<b>66.2</b>	<b>66.2</b>
33510	Байгууллагаас авах авлага	66.2	66.2
<b>33600</b>	<b>Зээлийн авлага</b>	<b>231,177.1</b>	<b>248,941.1</b>
<b>33610</b>	<b>Дотоод эх үүсвэрээс олгосон зээлийн авлага</b>	<b>231,177.1</b>	<b>248,941.1</b>
33612	Хувь хүмүүст олгосон зээл	231,177.1	248,941.1
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>126,266.0</b>	<b>67,770.5</b>
35300	Бэлэн бүтээгдэхүүн	0.0	727.4
<b>35400</b>	<b>Хангамжийн материал</b>	<b>116,266.0</b>	<b>56,823.1</b>
35410	Бичиг хэргийн материал	5,155.9	5,543.2
35420	Аж ахуйн материал	17,176.1	21,089.9
35430	Сэлбэг хэрэгсэл	4,388.0	7,288.0
35470	Бусад хангамжийн материал	89,546.0	22,902.0
35600	Мал амьтад	10,000.0	10,220.0
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>6,365,161.7</b>	<b>6,685,615.5</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>6,365,161.7</b>	<b>6,685,615.5</b>
<b>39200</b>	<b>Биет хөрөнгө</b>	<b>6,345,353.7</b>	<b>6,665,807.5</b>
39201	Барилга, байгууламж, орон сууц	2,013,044.4	2,238,014.7
39202	Хуримтлагдсан элэгдэл	-607,485.5	-695,469.0
39203	Авто-тээврийн хэрэгсэл	170,644.8	176,740.0
39204	Хуримтлагдсан элэгдэл	-129,874.6	-54,806.0
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	238,441.2	279,054.2
39206	Хуримтлагдсан элэгдэл	-156,618.1	-166,678.0
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	62,993.2	59,088.7
39208	Хуримтлагдсан элэгдэл	-48,778.9	-45,013.4
39209	Зам, гүүрийн байгууламж	4,753,858.5	4,753,858.5
39210	Хуримтлагдсан элэгдэл	-58,678.1	-133,901.3
39214	Бусад үндсэн хөрөнгө	166,455.5	333,455.5
39215	Хуримтлагдсан элэгдэл	-58,648.7	-78,536.6
<b>39300</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	<b>19,808.0</b>	<b>19,808.0</b>
39301	Програм хангамж	539.0	539.0
39302	Хуримтлагдсан элэгдэл	-539.0	-539.0
39303	Бусад биет бус хөрөнгө	19,808.0	19,808.0
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>7,218,837.4</b>	<b>7,456,343.5</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>16,077.5</b>	<b>50,337.2</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>16,077.5</b>	<b>50,337.2</b>
<b>41300</b>	<b>Өглөг</b>	<b>16,077.5</b>	<b>50,337.2</b>
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	479.9	92.8
<b>41360</b>	<b>Бусад өглөг</b>	<b>15,597.6</b>	<b>50,244.4</b>



41361	Байгууллагад төлөх өглөг	15,597.6	50,182.9
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	0.0	61.5
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>7,202,759.8</b>	<b>7,406,006.3</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>7,202,759.8</b>	<b>7,406,006.3</b>
51100	Засгийн газрын оруулсан капитал	1,284,112.4	1,284,112.4
511002	Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө	1,284,112.4	1,284,112.4
<b>51200</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>5,710,096.7</b>	<b>5,913,392.0</b>
51210	Өмнөх үеийн үр дүн	6,643,012.3	5,710,145.5
51220	Тайлант үеийн үр дүн	-932,915.6	203,246.5
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	208,550.7	208,501.9
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>7,218,837.4</b>	<b>7,456,343.5</b>

**2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан (мянган төгрөгөөр)**

Код:	Тайлангийн үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>1,948,438.4</b>	<b>1,836,700.3</b>
<b>11</b>	<b>ТАТВАРЫН ОРЛОГО</b>	<b>199,620.3</b>	<b>277,522.9</b>
110	Орлогын албан татвар	138,332.5	174,624.1
1100	Хувь хүний орлогын албан татвар	138,332.5	174,624.1
113	Хөрөнгийн албан татвар	25,865.0	35,637.4
118	Бусад татвар, төлбөр, хураамж	35,422.9	67,261.4
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>330,121.2</b>	<b>436,992.1</b>
120	Нийтлэг татварын бус орлого	330,121.2	436,992.1
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1,418,696.9</b>	<b>1,122,185.3</b>
<b>II</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>1,503,166.1</b>	<b>1,525,428.3</b>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,503,166.1	1,525,428.3
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	578,950.3	1,499,518.1
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	268,453.2	434,212.8
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	33,743.1	54,605.5
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	24,245.6	29,560.6
2104	Хангамж, бараа материалын зардал	45,881.6	465,480.4
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	80.0	36,379.4
2107	Томилолт, зочны зардал	1,454.0	6,918.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	36,231.3	327,857.8
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	168,861.5	144,503.5
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	924,215.8	25,910.2
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)</b>	<b>445,272.4</b>	<b>311,271.9</b>
<b>V</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>1,607,602.1</b>	<b>0.0</b>
<b>VI</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)</b>	<b>-1,162,329.7</b>	<b>311,271.9</b>

**2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан (мянган төгрөгөөр)**

Код:	Тайлангийн үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>1,966,055.0</b>	<b>1,544,813.1</b>
<b>11</b>	<b>ТАТВАРЫН ОРЛОГО</b>	<b>199,620.3</b>	<b>277,522.9</b>
110	Орлогын албан татвар	138,332.5	174,624.1
1100	Хувь хүний орлогын албан татвар	138,332.5	174,624.1
113	Хөрөнгийн албан татвар	25,865.4	35,637.4
118	Бусад татвар, төлбөр, хураамж	35,422.4	67,261.4
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	2,002.6	3,715.1
1181	Газрын төлбөр	1,211.8	906.3
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	32,208.0	62,640.0
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>104,628.0</b>	<b>145,104.9</b>
120	Нийтлэг татварын бус орлого	104,628.0	145,104.9
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1,661,806.6</b>	<b>1,122,185.3</b>
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>1,634,985.4</b>	<b>1,224,874.6</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,634,985.4</b>	<b>1,224,874.6</b>
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	674,643.4	1,109,113.9
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	307,067.8	432,145.7
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	37,859.8	54,602.9
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	186,994.2	282,130.4
2104	Хангамж, бараа материалын зардал	33,205.1	36,896.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,020.9	59,581.9
2107	Томилолт, зочны зардал	4,982.0	6,918.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	8,622.1	26,372.5
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	91,891.5	210,466.4
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	960,342.0	115,760.6
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)</b>	<b>331,069.6</b>	<b>319,938.5</b>
<b>V</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)</b>	<b>188,218.6</b>	<b>428,498.5</b>
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	188,218.6	428,498.5
2200	Дотоод эх үүсвэрээр	188,218.6	428,498.5
<b>VI</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)</b>	<b>-188,218.6</b>	<b>-428,498.5</b>
<b>VIII</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)</b>	<b>142,851.0</b>	<b>-108,560.0</b>
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	211,051.6	353,902.7
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	353,902.7	245,342.7

**2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан (мянган төгрөгөөр)**

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	3,406,312.1	0.0	3,406,312.1
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-131,780.1	0.0	-131,780.1
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	3,274,532.0	0.0	3,274,532.0
9	Тайлант үеийн үр дүн	-1,162,329.7	0.0	-1,162,329.7
10	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,112,202.2	0.0	2,112,202.2
11	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	2,112,202.2	0.0	2,112,202.2
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-4,310.8	0.0	-4,310.8
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,107,891.4	0.0	2,107,891.4
19	Тайлант үеийн үр дүн	311,271.9	0.0	311,271.9
20	2023 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	2,419,163.4	0.0	2,419,163.4

**2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан (мянган төгрөгөөр)**

Код	Үзүүлэлт	Батлагдсан төсөв	Гүйцэтгэлийн тайлан
II	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>2,273,808.0</b>	<b>1,926,386.3</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,540,916.1</b>	<b>1,469,776.2</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,526,816.1</b>	<b>1,464,616.2</b>
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>585,143.7</b>	<b>579,233.2</b>
210101	Үндсэн цалин	347,771.9	346,266.1
210102	Нэмэгдэл	191,171.8	148,050.0
210104	Урамшуулал	0.0	43,120.7
210105	Гэрээт ажлын хөлс	46,200.0	41,796.4
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>74,617.9</b>	<b>55,778.4</b>
210201	Тэтгэврийн даатгал	50,732.0	38,041.0
210202	Тэтгэмжийн даатгал	5,971.5	4,609.3
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,777.3	3,956.5
210204	Ажилгүйдлийн даатгал	1,194.3	1,062.7
210205	Эрүүл мэндийн даатгал	11,942.8	8,108.9
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>401,033.6</b>	<b>395,205.0</b>
210301	Гэрэл, цахилгаан	33,101.1	30,714.3



210302	Түлш, халаалт	363,748.5	361,431.6
210303	Цэвэр, бохир ус	4,184.0	3,059.2
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>108,013.4</b>	<b>105,375.6</b>
210401	Бичиг хэрэг	24,439.3	23,300.9
210402	Тээвэр, шатахуун	63,056.8	62,114.1
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5,317.3	5,285.5
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	12,600.0	12,375.1
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,600.0	2,300.0
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>6,800.0</b>	<b>6,793.0</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	800.0	800.0
210502	Хоол, хүнс	6,000.0	5,993.0
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>53,985.0</b>	<b>53,837.8</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	27,485.0	27,449.9
210604	Урсгал засвар	26,500.0	26,387.9
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>11,500.0</b>	<b>10,381.0</b>
210702	Дотоод албан томилолт	11,500.0	10,381.0
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>140,163.7</b>	<b>121,859.0</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	133,999.7	117,701.7
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,000.0	0.0
210803	Даатгалын үйлчилгээ	750.0	119.3
210804	Тээврийн хэрэгслийн татвар	660.0	461.5
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	190.0	110.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,564.0	3,466.6
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>145,558.8</b>	<b>136,153.2</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	141,358.8	131,953.4
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,200.0	4,199.8
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>14,100.0</b>	<b>5,160.0</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>14,100.0</b>	<b>5,160.0</b>
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	500.0	500.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	13,600.0	4,660.0
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>732,891.9</b>	<b>456,610.1</b>
220001	Барилга байгууламж	732,891.9	456,610.1
<b>III</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>2,273,808.0</b>	<b>1,904,046.6</b>
<b>31</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>343,699.4</b>	<b>0.0</b>
310004	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих	343,699.4	0.0
<b>32</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>1,514,313.8</b>	<b>1,786,435.6</b>
320001	Орон нутгийн төсвөөс	1,514,313.8	1,451,535.0
320002	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	0.0	334,900.6
<b>35</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	<b>278,097.5</b>	<b>117,610.9</b>
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	55,000.0	116,610.9

350002	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,000.0	1,000.0
350003	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	222,097.5	0.0
<b>36</b>	<b>ТУСЛАМЖИЙН ЭХ ҮҮСВЭРЭЭС САНХҮҮЖИХ</b>	<b>137,697.3</b>	<b>0.0</b>
360001	Тусламжийн эх үүсвэрээс санхүүжих	137,697.3	0.0
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.0	222,097.7
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.0	199,758.0

## 2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан (мянган төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	15,169,3	218,438,6
21	УРСГАЛ ЗАРДАЛ	15,169,3	218,438,6
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	15,169,3	218,438,6
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	15,169,3	218,438,6
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	15,169,3	218,438,5
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	15,169,3	218,438,6
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	15,169,3	218,438,6
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	15,169,3	218,438,6

## 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Галуут сум нь бид эрүүл, чинээлэг, хөгжсөн иргэнтэй, байгальд ээлтэй хөдөө аж ахуй, байгаль орчин, аялал, жуулчлал, үйлдвэрлэл үйлчилгээг цогцоор нь хөгжүүлсэн эдийн засгийн чадамжтай Амарбуянт бүсийн төв, улсын жишиг сум болно” эрхэм зорилготой ажилласан байна.

Дээрх эрхэм зорилгынхоо хүрээнд хүний хөгжлийн дээдлэн жижиг дунд үйлдвэрлэл, үйлчилгээг эрчимтэй дэмжиж иргэдийг тогтвортой ажлын байраар хангах, ядуурлыг бууруулахад төрийн байгууллагын бодлого, үйл ажиллагааг чиглүүлэх стратегийн зорилтыг хэрэгжүүлэх байгууллагын эрхэм зорилтыг дэвшүүлсэн байна.

### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй гэж үзлээ.

Галуут сумын төсөвт байгууллагуудын мөрдөж байгаа Баянхонгор аймгийн СТХС-ээс 2021 онд бэлтгэн гаргасан нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Галуут сумын Засаг даргын харьяа байгууллагууд, тусгай сангийн 2023 оны санхүүгийн үйл ажиллагаанд хууль хяналтын байгууллагаас хяналт хийгээгүй байна.



Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартад шаардсан зарчмын дагуу нягтлан бодох бүртгэлийн аккруз сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Галуут сумын Засаг даргын 2023 санхүүгийн нэгтгэсэн тайланг Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан "Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам"-ын дагуу бэлтгэсэн байна. Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн 7,456,343,4 мянган төгрөг байгаа нь өмнөх оноос 237,506,1 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	495,642,7	452,767,3	-42,875,4
Авлага	231,767,0	250,190,2	18,423,2
Бараа материал	126,265,9	67,770,4	-58,495,5
Хангамж	116,265,9	56,823,0	-59,442,9
Үндсэн хөрөнгө	6.365.161.7	6.685.615.4	320.453.7
Хуримтлагдсан элэгдэл	(1.060.623)	(1.174.943.2)	-114.320.2
Нийт хөрөнгө	7.218.837.3	7.456.343.4	237.506.1
Өр төлбөр	16.077.5	50.337.1	34.259.6
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	7,202,759.8	7,406,006.2	203,246.4
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	7,218,837,3	7,456,343,4	237,506.1

Эх сурвалж: Галуут сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

#### 3.4.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 495,642,7 мянга, эцсийн үлдэгдэл 452,767.3 мянган төгрөг болж 42,875,4 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 2. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл /мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Касст байгаа бэлэн мөнгө	0	0	0	0
Банканд байгаа бэлэн мөнгө	495,642,7	452,767,3	(42,875,4)	100%
Орон нутгийн ерөнхий орлого	273.545.0	253,009.3	(20,535.7)	55,7%
Орон нутгийн хөгжлийн сан	182,238,7	171,103,4	(11,135,3)	38%
Хоршоо хөгжүүлэх сан	39,858,8	28,654,5	(11,204,3)	6,3%
Замд яваа мөнгөн хөрөнгө	0	0	0	0
Хадгаламж	0	0	0	0

<b>ДҮН</b>	<b>991,285,2</b>	<b>905,534,5</b>	<b>(85,750,7)</b>	<b>100%</b>
------------	------------------	------------------	-------------------	-------------

Эх сурвалж: Галуут сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэлд байгаа 452,767.3 мянган төгрөгийн 55.7 хувь буюу 253,009.3 мянган төгрөг нь орон нутгийн ерөнхий орлогын дансны үлдэгдэл бол 38 хувь буюу 171,103,4 мянган төгрөгийн нь ОНХС-ийн харилцах дансны үлдэгдэл, 6,3 хувь буюу 28,654.5 мянган төгрөг нь Хоршоо хөгжүүлэх сангийн үлдэгдэл байна.

Төрийн сангийн орон нутгийн ерөнхий орлогын данс дахь 253,009.3 мянган төгрөгийн 59,381.1 мянган төгрөг нь төсөвт байгууллагуудын оны эцэст буцааж төвлөрүүлсэн төвлөрүүлэх шилжүүлэг, 193,628.2 мянган төгрөг нь орон нутгийн орлого давснаас шалтгаалан төсвийн зарцуулагдаагүй үлдэгдэл байна.

### 3.4.2 Авлага

Оны эхний 231,767.0 мянган төгрөгийн авлага 18,423.2 мянган төгрөгөөр нэмэгдэн оны эцэст 250,190.2 мянган төгрөгийн авлагатай гарчээ.

Хүснэгт 3. Авлагын үлдэгдэл / мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Бусад авлага	66,2	66,2	-	0,02
Ажиллагсадтай холбоотой	523,7	1,183.0	659,3	0,48
Хувь хүмүүст олгосон зээл	231,177,1	248,941,0	17,763.9	99,5
<b>ДҮН</b>	<b>231,767,0</b>	<b>250,190,2</b>	<b>18,423,2</b>	<b>100.0</b>

Эх сурвалж: Галуут сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн нийт авлагын 99.5 хувийг Хоршоо хөгжүүлэх сангаас олгосон хувь хүмүүст олгосон зээл эзэлж байгаа ба авлагын 0,5 хувийг сумын ЗДТГ, ИТХ-ийн авлага эзэлж байна.

Хүснэгт 4. Авлагын үлдэгдэл байгууллагаар /мянган төгрөгөөр/

№	Байгууллагын нэр	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Үүнээс:		
				Хувь хүмүүсээс авах авлага	Байгууллагаас авах авлага	Хувь хүмүүст олгосон зээл
1	ЗДТГ	109,6	109,7	0	109,7	
2	ИТХ	477,3	1,139.5		1,139,5	
3	ОНХС					
4	Хоршоо хөгжүүлэх сан	231,177.1	248,941.0			248,941.0
	<b>ДҮН</b>	<b>217,965.1</b>	<b>250,190.2</b>		<b>1,249.1</b>	<b>248,941.0</b>

Эх сурвалж: Галуут сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Оны эцсийн авлагын 0.02 хувийг сумын ЗДТГ-ын 109.7 мянган төгрөгийн авлагын 66,2 урд оны татвараас авах авлага барагдаагүй, 43.5 мянган төгрөг нь нийгмийн даатгалын байгууллагаас авах авлага шинээр үүссэн, 0.48 хувийг сумын ИТХ-ийн 1,139.5 мянган төгрөгийн авлагын 477.3 мянган төгрөгийн өмнөх оны авлага барагдаагүй, шинээр үүссэн ажиллагсдаас авах авлага 662.2 мянган төгрөг, 99.5 хувь буюу хоршоо хөгжүүлэх сангийн 21,003.5 мянган төгрөгийн хувь хүмүүсээс авах авлага нь өмнөх онд үүссэн авлага барагдаагүй, шүүх хяналтын байгууллагад шилжүүлсэн, хувь хүмүүсээс төлөлтийн хуваарийн дагуу төлөгдөх 227,937.5 мянган төгрөгийн авлага тус тус байна.

### 3.4.3 БАРАА МАТЕРИАЛ

Бараа материалын эхний үлдэгдэл 126,265.9 мянга, эцсийн үлдэгдэл 67,770.4 мянган төгрөг болж, 74,792.5 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 5. Бараа материалын үлдэгдэл /мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Тусгай зориулалтын материал				
Аж ахуйн материал	17,176,1	21,089,8	3,913,7	31
Бичиг хэргийн материал	5,155,8	5,543,2	387,4	8,1
Сэлбэг хэрэгсэл	4,388,0	7,288,0	2,900	10,7
Мал амьтад	10,000	10,220,0	220,0	15,0
Бэлэн бүтээгдэхүүн		727,4	727,4	1,0
Бусад хангамжийн материал	89,545,9	22,901,9	66,644	34,2
Нөөцийн бараа				
<b>Дүн</b>	<b>126,265,9</b>	<b>67,770,4</b>	<b>74,792,5</b>	<b>100.0</b>

Эх сурвалж: Галуут сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Бараа материалын эцсийн үлдэгдлийн 34.2 хувь бусад хангамжийн дансны үлдэгдэл, 31 хувь аж ахуйн материал тус тус эзэлж байна.

Хүснэгт 6. Бараа материалын үлдэгдэл байгууллагаар /мянган төгрөгөөр/

№	Байгууллагын нэр	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
1	ЗДТГ	118,750,3	58,519.4	(60.230.9)	86.4
2	ИТХ	7,515,6	9,251.0	1.735.4	13.6
3	ОНХС				
	<b>ДҮН</b>	<b>126,265,9</b>	<b>67,770.4</b>	<b>(58.495.5)</b>	<b>100.0</b>

Эх сурвалж: Галуут сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд 289,812.2 мянган төгрөгийн бараа материалыг төсвийн хөрөнгөөр худалдан авч, 49,037.0 мянган төгрөгийн бараа материал бусад байгууллагаас үнэ төлбөргүй шилжиж авч, хандиваар 2,220.0 үйл ажиллагаанд 399,564.7 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулсан байна.

3.4.4 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл 7,425,784.7 мянга, эцсийн үлдэгдэл 7,860,558.7 мянган төгрөг болж, 434,774.0 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 7. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл /мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Барилга байгууламж, орон сууц	2,013,044,4	2,238,014,7	224,970,3	28
Тээврийн хэрэгсэл	170,644,8	176,740,0	6095,2	2,2
Машин тоног төхөөрөмж	238,441,2	279,054,2	40,613	3,5
Тавилга эд хогшил	62,993,1	59,088,6	(3,904,5)	0,8
Гүүрний байгууламж	4,753,858,5	4,753,858,5	0	61
Бусад үндсэн хөрөнгө	166,455,5	333,455,5	167,000	4,2
Программ хангамж	539,0	539,0	0	0,007
Бусад биет бус хөрөнгө	19,808,0	19,808,0	0	0,25
<b>Дүн</b>	<b>7,425,784,7</b>	<b>7,860,558,7</b>	<b>434,774</b>	<b>100.0</b>

Эх сурвалж: Галуут сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд төсвийн хөрөнгөөр 68,629.9 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авч, 58,000.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг бусад байгууллагаас шилжүүлэн авсан, хандив тусламжаар 456,689.3 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө тус тус авсан бөгөөд сумын ЗДТГ-ын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй холбогдох газрын

шийдвэрээр бүртгэлд тусгасан авто тээврийн хэрэгсэл, тавилга эд хогшил, тоног төхөөрөмжийг акталсан байна.

Хүснэгт 8. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл байгууллагаар /мянган төгрөгөөр/

№	Байгууллагын нэр	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
1	ЗДТГ	7,370,307.6	6,676,603.4	(693,704.2)	99.8%
2	ИТХ	55,477.1	9,012.0	(46,465.1)	0.2%
	<b>ДҮН</b>	<b>7,425,784.7</b>	<b>6,685,615.4</b>	<b>(740,169.3)</b>	<b>100.0</b>

Эх сурвалж: Галуут сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

### 3.4.5 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн эхний үлдэгдэл 16,077.5 мянган төгрөгийн үлдэгдэл, шинээр нэмэгдсэн 50,337.1 мянган төгрөгийн байгууллагад төлөх өглөгийн үлдэгдэлтэй болсон байна.

Хүснэгт 9. Нийт өр төлбөрийн үлдэгдэл /мянган төгрөгөөр/

№	Байгууллагын нэр	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Ажиллагсадтай холбоотой	Үүнээс:	
					Байгууллагад төлөх өглөг	Хувь хүмүүст өглөг
1	ЗДТГ	10,0	37,1	0.0	37,1	0.0
2	ИТХ	480,0	154,3	92,8		61,5
3	ОНХС	15,587,6	50,145,7		50,145.7	
	<b>ДҮН</b>	<b>16,077,5</b>	<b>50,337,1</b>	<b>92,8</b>	<b>50,182.8</b>	<b>61,5</b>

Эх сурвалж: Галуут сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

ЗДТГ 37.1 мянган төгрөгийн татварын өглөг, ИТХ 92.8 мянга ҮЭ-ийн өглөг, 61.5 мянга цалингийн зөрүү, ОНХС-ийн 50,145.7 мянган төгрөг он дамжсан ажлын үлдэгдэл санхүүжилт оготно устгал, гүний худаг гаргах ажлууд байна.

### 3.4.6 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл 7,202,759.8 мянга, эцсийн үлдэгдэл 7,406,006.2 мянган төгрөг болж, 153,063.6 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна.

Хүснэгт 10. Засгийн газрын хувь оролцоо /мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт+/ бууралт -/	Дүнд эзлэх хувь
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,284,112,3	1,284,112,3	-	0.2
Хуримтлагдсан үр дүн	5,710,096,7	5,913,391,9	203,295,2	80
Өмнөх үеийн үр дүн	6,643,012,3	5,710,145,5	(932,866.8)	
Тайлант үеийн үр дүн	-932,915,6	203,246,4	(1.136.162)	
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	208,550,7	208,501,9	-	8
<b>Дүн</b>	<b>7,202,759,8</b>	<b>7,406,006,2</b>	<b>1,865,733.6</b>	<b>100.0</b>

Эх сурвалж: Галуут сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Өмнөх үеийн үр дүн дансны үлдэгдэл өмнөх оноос 932,866.8 мянган төгрөгөөр нэмэгдсэн, мөн дүнгээр хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү данс буурсан нь сумын ЗДТГ-ын санхүүгийн тайланд бүртгэлтэй үндсэн хөрөнгийг акталсантай холбоотой байна.

### 3.4.7 Орлогын данс

Галуут сумын ИТХ-ын хуралдааны 2022 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн 10/03 дугаар тогтоолоор сумын төсвийн татварын орлогыг 588,865.5 мянга, татварын бус торгуулийн орлогыг 21,000.0 мянган, нийт 609,865.5 мянган төгрөгөөр баталсныг 2023

005

ТӨСВИЙН ХУРААНГАЙН БАЙГУУЛЛАГА  
ӨӨРЧДӨЛТГҮЙ  
САНАЛ ДҮГНЭЭЛТ

оны 07 дугаар сарын 07-ны өдрийн 13/03 дугаар тогтоолоор цалин хөлс, түүнтэй адилтгах орлогыг 16,550.0 мянган, газрын дуудлага худалдааны орлогыг 15,000.0 мянган төгрөгөөр тус тус нэмэгдүүлснээр татварын орлогыг 641,415.5 мянган төгрөгөөр баталжээ.

Хүснэгт 11. Төвлөрүүлэх орлого /мянган төгрөгөөр/

Орлогын нэр	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
<b>Хувь хүний орлогын албан татвар</b>	<b>243,750.0</b>	<b>258,586</b>	<b>(14,836)</b>	<b>117.0</b>
1. Цалин хөлс, түүнтэй адилтгах орлого	182,050.0	207,116.8	(25,066.8)	113.8
2. Үйл ажиллагааны орлого	23,500.0	13,786.1	9,713.9	145.0
3. ҮХЭХ борлуулсны орлого	4,000.0	1,426.0	2,574.0	356.9
4. Хадгаламжийн хүү	34,200.0	36,257.1	(2,057.1)	105.7
<b>Өмчийн татвар</b>	<b>7,485.0</b>	<b>7,601.9</b>	<b>(116.9)</b>	<b>101.6</b>
1. Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар	1,800	1,866.9	(66.9)	71.5
2. Бууны албан татвар	5,685.0	5,735.0	(50.0)	75.0
<b>Бусад татвар, төлбөр хураамж</b>	<b>370,180.5</b>	<b>560,724.7</b>	<b>(190,544.2)</b>	<b>128.6</b>
1. Улсын тэмдэгтийн хураамж	13,000.0	14,282.1	(1,282.1)	212.7
2. Газрын төлбөр	66,700.0	50,476.1	16,223.9	87.6
3. Түгээмэл тархцатай АМНАТ	6,000.0	4,000.0	2000.0	60.0
4. Малын тоо толгойн албан татвар	69,256.5	65,543.1	3,713.4	67.3
5. Хог хаягдлын үйлчилгээний хураамж	12,000.0	8,450.0	3,550.0	75.5
6. Ус рашаан ашигласны төлбөр		173.6	(173.6)	130.7
7. Ан амьтны нөөц ашигласны төлбөр	181,224.0	399,282.5	(217,058.5)	203.7
8. Газрын дуудлага худалдааны орлого	21,000.0	18,517.3	2,482.7	-
<b>Татварын бус орлого</b>	<b>21,000.0</b>	<b>17,821.1</b>	<b>3,178.9</b>	<b>84.9</b>
1. Төсөвт байгууллагын өөрийн орлого	1,000.0	1000.0	-	100
2. Торгуулийн орлого	20,000.0	16,821.1	3,178.9	84.1
<b>Орлогын нийт дүн</b>	<b>641,415.5</b>	<b>826,912.6</b>	<b>(205,497.1)</b>	<b>133.1</b>

Эх сурвалж: Галуут сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Сумын төсөвт төвлөрөх татварын орлогыг 13361 хувь буюу 205,49761 мянган төгрөгөөр давуулан биелүүлсэн нь дараах орлогууд давж биелсэнтэй холбоотой байна. Үүнд:

- Тайлант онд төрийн албан хаагчдын цалин нэмэгдсэнтэй холбоотой цалин хөлс, түүнтэй адилтгах орлого 113.0 хувиар биелсэн;
- Боловсролын байгууллагын жилийн гүйцэтгэлийн үнэлгээгээр амжилттай үнэлэгдсэн багш нарт урамшуулал олгосон нь үйл ажиллагааны орлого давах шалтгаан болсон;
- Засгийн газрын 2017 оны 339 дүгээр тогтоолыг үндэслэн аймгийн БОАЖГ-ын дарга, аж ахуйн нэгжүүдтэй 2023 оны 07 дугаар сарын 25-ны өдөр байгуулсан “Агнуурын амьтан агнах” гэрээний дагуу тайлант онд 1 угалз, 2 тэх агнасан агнуурын орлогоос 14,282,1 мянган төгрөгийн тэмдэгтийн хураамж, 65,202,5 мянган төгрөгийн ан агнуурын орлого, шонхрын орлогоос 334,080.0 мянган төгрөг нийт 399,282.5 мянган төгрөг орон нутагт төвлөрсөн байна.

Харин иргэд үл хөдлөх хөрөнгийн албан татвар, хог хаягдлын үйлчилгээний хураамж, буу, газрын төлбөр, малын тоо толгойн албан татвар төлөх үүргээ бүрэн биелүүлээгүйгээс тус орлогууд тасарсан байгаа байна.

Төсөвт байгууллагын өөрийн орлогыг сумын ИТХ батлахдаа сумын ЗДТГ өөрийн орлогоор 1,000.0 мянга, Хоршоо хөгжүүлэх сангаас олгосон зээл, хүүгийн эргэн төлөлтийн орлогоор 55,000.0 мянган төгрөг оруулахаас гүйцэтгэлээр сумын ЗДТГ орлогыг биелүүлсэн байна.

Хүснэгт 12. Өөрийн орлого /мянган төгрөгөөр/

№	Сумын нэр	Байгууллагын нэр	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь	Өөрийн орлогын эх үүсвэрийн талаар тайлбар
1	Галуут	ЗДТГ	1,000.0	1,000.0	-	100%	Авто тээврийн хэрэгсэл акталсан
2	Галуут	Сум хөгжүүлэх сан	55,000.0	71,895.6	16,895.6	130.7%	Зээлийн хүү, эргэн төлөлт
		<b>ДҮН</b>	<b>66,000.0</b>	<b>72,895.6</b>	<b>16,895.6</b>		

Эх сурвалж: Галуут сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

### 3.4.8 Зардлын данс

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 70105, 70106, 70503, 71602, 71801, 71802, 71806, 72101 гэсэн кодтой 8 хөтөлбөрт зориулан 2,273,808 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 1,926,386.2 мянган төгрөгийг гүйцэтгэлээр зарцуулснаас 1,469,776.1 мянган төгрөгийг урсгал зардалд, 395,205.0 мянган төгрөгийг тогтмол зардалд, 456,610.0 мянган төгрөгийг хөрөнгийн зардалд зарцуулсан байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Галуут сумын Засаг даргын санхүүгийн тайланд нэгтгэгддэг 2 төсвийн байгууллага төсвийн төслийг бэлтгэж, улсын төсвийн байгууллагын тогтмол зардлыг төлөвлөж хүргүүлсэн аймгийн СТСХ-т хүргүүлсэн ба сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2022 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн 10/03 дугаар тогтоолоор сумын төсвийн нийт зардлыг 2,059,788.8 мянган төгрөгөөр баталсан байна.

#### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 9 хөтөлбөрийн арга хэмжээний зардалд сумын ИТХ-ын хуралдааны 2022 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн тогтоолоор анх 2,059,788.8 мянган төгрөгөөр баталсан, анхны төсөвт сумын ИТХ-ын хуралдааны 2023 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн 13/03 дугаар тогтоолоор төсөвт тодотгол хийж, урьд оны үлдэгдлийг 84,875.9 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, аймгийн орон нутгийн хөгжлийн сангаас олгох санхүүжилтийг 43,048.8 мянга, аймгийн төсвөөс олгох санхүүгийн дэмжлэгийг 137,836.9 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн анхны төсвөөс нийт дүнгээр 265,761.6 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн төсвийг 2,273,808.0 мянган төгрөгөөр баталсан байна.

Хүснэгт 12. Галуут сумын Засаг даргын 2023 оны төсвийн санхүүжүүлэх эх үүсвэр /мянган төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Анхны баталсан 2022.12.19 өдрийн 10/03 тогтоол	Сумын ИТХ-ын 2023.07.07-ны өдрийн 13/03 тогтоол	Дүнд эзлэх хувь
1	Татварын орлого	609,865.5	620,415.5	27,2
2	Татварын бус орлого /торгуулийн орлого/	20,000	20,000	0.8
3	Аймгийн төсвөөс олгох санхүүгийн дэмжлэг	503,578,6	601,172	26,7
4	Сумын төсөвт аймгийн ОНХС-аас олгох шилжүүлэг	300,650,6	343,699,4	15,1
5	Өөрийн орлого ЗДТГ	1,000.0	1,000.0	0.04
6	Өөрийн орлого Хоршоо хөгжүүлэх сан	55,000	55,000	2.4

7	Сумын төсвийн урьд оны үлдэгдэл	187,850,4	272,726,3	12
8	Сумын ОНХС-ийн урьд оны үлдэгдэл	182,238,7	182,238,7	8
9	Сумын хоршоо хөгжүүлэх сангийн урьд оны үлдэгдэл	39,858,8	39,858,8	1,7
10	Хандив тусламжийн орлого	180,746,1	137,697,3	6
<b>ДҮН</b>		<b>2,059,788.8</b>	<b>2,273,808.0</b>	<b>100</b>

Эх сурвалж: Галуут сумын ИТХ-ын хуралдааны 2022 оны 12/07, 2023 оны 15/03 дугаар тогтоол

*Хүснэгт 13. Төсвийн гүйцэтгэл байгууллагаар /мянган төгрөгөөр/*

№	Байгууллагын нэр	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь	ОНТ-т төвлөрүүлсэн
1	ЗДТГ	943,100,4	893,813,3	49,287,0	94,7	49,287,0
2	ИТХ	149,856,8	145,562,2	4,294,5	97,1	4,294,6
3	ЕБС	165,911,7	165,629,7	281,9	66,2	281,9
4	Бага сургууль	14,060,0	12,478,2	1,582,0	88,7	1,582,0
4	Цэцэрлэг	44,762,2	43,746,9	1,015,2	97,7	1,015,2
5	ЭМТ	44,003,8	41,316,1	2,687,6	93,8	2,687,6
6	Соёлын төв	84,362,4	84,129,8	232,5	91,4	232,5
7	ОНХС	732,891,9	456,610	276,281,8	62,3	
8	СХС	94,858,8	83,100,0	11,758,8	87,6	-
9	Орон нутгийн сан				0.0	
<b>ДҮН</b>		<b>2,273,808</b>	<b>1,926,386,2</b>	<b>347,421,3</b>	<b>84,7</b>	<b>59,381,1</b>

Эх сурвалж: Галуут сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,926,386.2 мянган төгрөг буюу 84.7 хувьтай байгаа нь тогтмол зардлыг 5,799.2 мянган төгрөгөөр, Засаг даргын тамгын газрын Байгаль орчныг нөхөн сэргээх, хамгаалах зардал 14,000.0 төгрөг хэмнэсэн, ОНХС-аас хэрэгжүүлэн төсөл арга хэмжээг 276,281.5 мянган төгрөгөөр дутуу хэрэгжүүлсэн, Сум хөгжүүлэн сангаас олгохоор төлөвлөсөн зээлийг 11,000.0 мянган төгрөгөөр дутуу олгосон, 137,697.3 мянга, хандив, тусламжийн орлогоор оруулахаар төлөвлөсөн боловч оруулаагүй зэрэгтэй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Галуут сумын ЗДТГ-ын нэмэлт санхүүжилтийн дансанд 217,138,6 мянга, ИТХ-ын нэмэлт санхүүжилтийн дансанд 1,300,0 мянга, нийт 218,438,6 мянган төгрөгийн санхүүжилт орсноос бараа үйлчилгээний бусад зардалд 218,138,5 мянган төгрөгийг зарцуулан, ИТХ нийт 0,1 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

#### 3.5.3 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Сумын ИТХ-аас баталсан ОНХС болон Хоршоо хөгжүүлэх сангаас өөр төсөл хөтөлбөр хэрэгжээгүй болно.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Галуут сумын Засаг даргын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгохтой холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор М.Алтантуяа гүйцэтгэж, үе шатны хяналтыг дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат хэрэгжүүлсэн.

Галуут сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2024.03.05-ны өдөр ирүүлсэн байна.

Галуут сумын Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайланд 1 дүгээр гарын үсгийг сумын Засаг дарга А.Батбаяр, 2 дугаар гарын үсгийг сумын санхүүгийн албаны дарга Б.Анхбаяр нар зурж хөрөнгийг захиран зарцуулсан байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2023 оны баталсан төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны ний зардал 2,481,524.7 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 24,715.2 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 17,370.7 мянган төгрөгөөр тогтоосон, төлөвлөлтийн шатны материаллаг байдлыг гүйцэтгэлийн үе шатанд хянаж үзээд шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Галуут сумын Засаг даргын харьяаны төсөвт байгууллагууд Төрийн хэмнэлтийн тухай хуулийг мөрдөж ажилласнаар дараах зардлуудыг хэмнэсэн байна. Үүнд:

- Сумын ЗДТГ нь байгаль орчны байцаагч, хөдөө аж ахуйн тасгийн 2 мэргэжилтэн орон тоо дутуу ажилласан тул цалин, ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлийн зардал, урамшууллын зардал хэмнэгдсэн;
- Байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх зардлыг гүйцэтгэлээр нь санхүүжүүлсэн байна.
- Нэг удаагийн шагнал тэтгэмж урамшууллын зардлыг гүйцэтгэлээр мөн санхүүжүүлсэн байна.

Хүснэгт 14. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт /мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	585,143,7	579,233,2	5,910,5	98,9

2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	74,617,9.0	55,778,3	18,839,6	74,7
210901	Байгаль орчныг нөхөн сэргээх	114,000,0	99,200,0	14,800,0	87

Эх сурвалж: Галуут сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

#### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

##### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Галуут сумын Засаг даргын шилэн дансны нэгдсэн цахим хуудаст 89 мэдээлэл оруулахаас 87 мэдээллийг хугацаанд нь байршуулж, 2 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

#### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

##### 4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудитаар орлогыг төлөвлөгөө, гүйцэтгэлийн авч үзсэн болно.

##### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Галуут сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Б.Азбаяр аудит хийж, малын тоо толгойн албан татварыг төсөвт бүрэн төвлөрүүлэх 33,345.0 мянган төгрөгийн 1 албан шаардлага өгч, хууль журмын хэрэгжилттэй холбоотой 1, дотоод хяналт хариуцлагатай холбоотой асуудал 1 асуудалд зөвлөмж өгснийг хэрэгжүүлэн ажилласан байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Төлбөрийн акт					100%
Албан шаардлага	1	33,345.0	1	33,345.0	100%
Зөвлөмж	2	2	2	2	100%
<b>Нийт дүн</b>	<b>7</b>	<b>40,493.5</b>	<b>7</b>	<b>40,493.5</b>	<b>100%</b>

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Байхгүй.

#### 4.7 Аудитын гол асуудал

Сумын Засаг даргын харьяа байгууллагуудын аудитын явцад хэрэгжүүлэх горим сорилыг төсвийн шатлалд хамаарах байгууллага, нэгж тус бүрээр төлөвлөж хэрэгжүүлсэн бөгөөд аудитын дүн, дүгнэлтийг нэгтгэсэн байдлаар үнэлж, гаргалаа.

Галуут сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд нэгтгэгдсэн ЗДТГ, ИТХ болон 2 тусгай сангийн санхүүгийн тайлан түүвэрт хамрагдаж, сумын Эрүүл мэндийн төв, Ерөнхий боловсролын сургууль, Цэцэрлэг, Соёлын төвийн орон нутгийн төсвөөс олгосон санхүүжилт, гүйцэтгэл төсвийн гүйцэтгэлийн тайланд нэгтгэгдсэн байна.

Галуут сумын Засаг даргын харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд нийт 895.9 мянган төгрөгийн 2 алдаа<sup>1</sup> илэрснээс аудитын явцад алдааг санхүүгийн тайланд залруулсан байна.

Хүснэгт 15. Төсвийн шууд захирагчийн алдаа зөрчлийн дүн /мянган төгрөгөөр/

№	Байгууллагын нэр	Аудитаар илрүүлсэн алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Алдаа, зөрчлийн шийдвэрлэлт
A	1	2	3	4
1	Галуут сумын ИТХ	Нийгмийн даатгалд өр төлбөргүй байхад санхүүгийн тайланд өр үүсгэж бүртгэсэн.	100.0	Залруулсан
2	Галуут сумын ИТХ	Суутган татварт 795923.8 төгрөгийн илүү төлж авлага үүсгэлгүйгээр зардалд бичиж хаасан байна.	795.9	Залруулсан
ДҮН			895.9	

Эх сурвалж: Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын зөрчлийн нэгтгэл

Галуут сумын сумын Засаг даргын харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар нийт 8,039.1 мянган төгрөгийн 5 зөрчил<sup>2</sup> илэрснээс, 200.0 мянган төгрөгийн зөрчилд 2 төлбөрийн акт тогтоож, зөрчлийг арилгах 302,279.8 мянган төгрөгийн 6 албан шаардлага ажилласан байна.

Хүснэгт 16. Төсвийн шууд захирагчийн зөрчлийн дүн /мянган төгрөгөөр/

№	Байгууллагын нэр	Аудитаар илрүүлсэн алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Алдаа, зөрчлийн шийдвэрлэлт	Материаллаг эсэх	Зөрчлийн ангилал
A	1	2	3	4	5	6
1	Галуут сумын ИТХ	Иргэн О.Амарзаяагаас 2,000.0 мянган төгрөгөөр компьютер худалдан авахдаа Е-баримтгүй худалдан авалт хийсэн. Хувь хүний орлогын албан татварын 10% суутган тооцоогүй байна.	200.0	Төлбөрийн акт	Материаллаг	Санхүүгийн аудит
2	Галуут сумын ИТХ	Он дамжсан, ажлаас гарсан ажилтантай холбоотой 343,667.54 төгрөгийн авлагыг барагдуулаагүй байна.	300.7	Албан шаардлага	Материаллаг	Санхүүгийн аудит
	Галуут сумын ИТХ	Төсөв, хөрөнгө, мөнгө зарцуулах 6.6 сая төгрөгийн 13 тушаал шийдвэрийг шилэн дансанд байршуулаагүй байна. 11 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан.	6,600.0	6,600.0	Материаллаг бус	Нийцлийн аудит
ДҮН			8,039.6			
НИЙТ АЛДАА, ЗӨРЧИЛИЙН ДҮН			8,039.6			

Эх сурвалж: Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын зөрчлийн нэгтгэл

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

<sup>2</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

## Аудитын илрүүлэлт

Аудитаар орон нутгийн төсвийг бүрдүүлж байгаа татварын орлогыг бүрэн биелүүлээгүй зөрчил илэрсэнд зөвлөмж хүргүүлэв.

### 5.1. ЗӨВЛӨМЖ

1. Илрүүлэлт: Галуут сумын орон нутгийн төсөвт төвлөрөх иргэд үл хөдлөх хөрөнгийн албан татвар, хог хаягдлын үйлчилгээний хураамж, буу, газрын төлбөр, малын тоо толгойн албан татвар төлөх үүргээ бүрэн биелүүлээгүйгээс тус орлогууд тасарсан байна.

Энэ нь Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28.1 дэх “Татвар төлөгч холбогдох татварын хуулиар төлбөл зохих татварын ногдлоо өөрөө тодорхойлж, хуулиар тогтоосон хугацаанд төсөвт төлнө”, Малын тоо толгойн албан татварын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2 дахь “Тухайн татварын жилд албан татвар ногдуулах малын тоо толгойг Статистикийн тухай хуульд заасны дагуу хийгдсэн өмнөх жилийн мал тооллогын дүнд үндэслэн тодорхойлно”, 7 дугаар зүйлийн 7.1 дэх “Албан татвар төлөгч энэ хуулийн дагуу ногдуулсан албан татварыг тэнцүү хоёр хуваан тухайн жилийн 7 дугаар сарын 15, 12 дугаар сарын 15-ны өдрийн дотор өөрийн өмчилж байгаа малын тоо толгой тоологдож бүртгэгдсэн сум, дүүргийн төсөвт төлнө” гэсэн заалтыг зөрчин, санхүүгийн тайлангийн “Нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Иймд сумын төсөвт төвлөрөх албан татварыг тайлант хугацаанд нь төсөвт бүрэн төвлөрүүлэх байх зөвлөмжийг хүргүүлэв.

Аудитаар өгсөн Зөвлөмж хэрэгжүүлэх төлөвлөгөөг 2024 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн дотор, хэрэгжилтийг 2024 оны 09 дүгээр сарын 20-ны өдрийн дотор нотлох баримтын хамт ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

(мянган төгрөгөөр)

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Галуут сумын орон нутгийн төсөвт төвлөрөх иргэд үл хөдлөх хөрөнгийн албан татвар, хог хаягдлын үйлчилгээний хураамж, буу, газрын төлбөр, малын тоо толгойн албан татвар төлөх үүргээ бүрэн биелүүлээгүйгээс тус орлогууд тасарсан байна.	1	0					1	0
Дүн	1	0				0	1	0